

Сэнкакү арлуудын тухай гурван үнэн

/шинэчилсэн/

2012 оны 10 дугар сарын 4
Япон улсын Гадаад хэргийн яам

1. Сэнкакү арлууд нь түүхийн хөдлөшгүй баримт болоод олон улсын хуулийн үүднээс үзвэл Япон улсын газар нутгийн салшгүй хэсэг мөн

- 1885 оноос эхлэн Япон улсын Засгийн газар нь Окинава мужийн захиргаанаар дамжуулан, мөн бусад арга хэлбэрээр Сэнкакү арлуудын талаар нарийвчилсан судалгаануудыг явуулж ирсэн билээ. Эдгээр судалгаануудын үр дүнд Сэнкакү арлууд дээр хүн амьдарч байгаагүй нь тогтоогдоод зогсохгүй Хятадын Чин гүрний мэдэлд байсан ямар нэгэн үл мөр олдоогүй байна. Энэхүү нотолгоонд үндэслэн 1895 оны 1 дүгээр сарын 14-ны өдөр Япон улсын Засгийн газар нь арлууд дээр хилийн шон босгож Сэнкакү арлуудыг Японы нутаг дэвсгэрт албан ёсоор нэгтгэх тухай шийдвэр гаргажээ. Эдгээр арга хэмжээнүүдийг олон улсын хуулийн хүрээнд газар нутагт эзэмшилээ тогтоох (эзэнгүй газар нутаг буюу *terra nullius*-т эзэмшилээ тогтоох) зарчмын дагуу явагдсан билээ. Ийнхүү эдгээр арлууд нь 1895 оны 5 дугаар сард хүчин төгөлдөр болсон Шимоносэкийн гэрээний 2 дахь заалтын дагуу Чин гүрнээс Японд шилжүүлсэн “Тайвань арал болон Пескадорын арлууд”-ын бүрэлдэхүүд орж байгаагүй бөгөөд, Япон улс нь эдгээр арлуудыг Япон-Чин гүрны дайны дүнд булаан аваагүй болно.
- Түүнээс хойш Сэнкакү арлууд нь Япон улсын хүчин төгөлдөр хяналтанд байсан билээ. Жишээлбэл, Сэнкакү арлын орчим загас барих зэрэг үйл ажиллагаа явуулдаг байсан Окинава мужийн нэгэн оршин суугч эдгээр арлуудыг түрээсээр ашиглах хүсэлтээ гаргасны үндсэн дээр тухайн үеийн Засгийн газар 1896 онд уг хүсэлтийг нь ёсоор болгожээ. Ийнхүү зөвшөөрлөө авсны дараа тэрээр ажилчдаа арлуудруу илгээн шувууны өд цуглуулах, хатаасан хар амар загас бэлтгэх, шүр цуглуулах, мал үржүүлэх, лаазалсан хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон түлшний зориулалтаар шувууны сангас цуглуулах зэрэг бизнесийн үйл ажиллагаа явуулж байв. Тухайн үеийн Японы засгийн газраас хувь хүнд Сэнакү арлуудыг ашиглах зөвшөөрөл олгож, тэрээр уг зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа

нээлттэйгээр явуулах боломжтой байсан нь эдгээр арлууд нь Япон улсын хүчин төгөлдөр хяналтанд байсныг илтгэж байгаа болно.

- Сэнкакү арлууд нь Тайваний бүрэлдэхүүнд буюу 1951 онд үзэглэсэн Сан-Францискогийн Энхийн гэрээний дагуу Японы хураалгасан нутаг дэвсгэрт багтаагүй билээ. Сэнкакү арлууд нь Нансэй арлуудын бүрэлдэхүүнд ордгийн хувьд АНУ-ын захиргаанд очсон бөгөөд 1971 онд үзэглэсэн Рюүкюү болон Дайтоо арлуудын талаархи Япон, АНУ-ын гэрээний дагуу Япон улс захирах эрхээ эргүүлэн авсан билээ.
- 1968 онд НҮБ-ын агентлаг судалгаа явуулсны дүнд Дорнод Хятадын тэнгист газрын тосны нөөц байж болзошгүйн шинж тэмдэг илрүүлснээс хойш буюу 1970 оноос эхлэн БНХАУ болон Тайвань Сэнкакү арлуудын эзэмшлийн асуудлыг анх тавьж эхэлжээ. Үүнээс өмнө аль нэгэн улс орон, бус нутгийн зүгээс Япон улсын эзэмшлийг Сэнкакү аралд тогтоосон талаар эсэргүүцэл илэрхийлж байгаагүй болно.
- Олон улсын хууль, эрхзүйн үүднээс үзвэл БНХАУ-ын Засгийн газраас гаргаад буй түүхэн, газарзүйн болоод геологийн хэмээгдэх нотолгоонууд нь Сэнкакү арлуудыг захиран тохинуулах тухай Хятадын мэдэгдэлүүдийн үндэслэл болж үл чадна. 1920 оны 5 дугаар сард Нагасаки дахь Хятадын консулаас Сэнкакү арлын орчим Фүжиан мужийн хятад загасчид осолдсонтой холбогдуулан ирүүлсэн талархлын захидалд “Японы эзэнт гүрний Окинава мужийн Яэяама дүүргийн Сэнкакү арлууд” хэмээн бичсэн байдаг. Түүнчлэн, БНХАУ-ын “Ардын Сонин”-ы 1953 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн дугаарт хэвлэгдсэн өгүүллэгт Рюүкюү арлууд нь “Сэнкакү арлуудыг багтаасан нийт 7 бүлэг арлаас бүрддэг” хэмээн тодорхой бичсэн байдаг. Мөн 1960 онд БНХАУ-д хэвлэгдсэн “Дэлхийн атлас”-т Сэнкакү арлуудыг Окинава арлуудын бүрэлдэхүүн хэсэг хэмээн харуулсан байна.

2. Япон улсын Засгийн газар Сэнкакү арлуудыг худалдан авсан нь тайван бөгөөд тогтвортой удирдлагаар хангах зорилтыг агуулсан

- Сэнкакү арлуудыг өмчлөх эрхийг олж авах тухай Япон улсын Засгийн газрын шийдвэр нь өнөөгийн байдлыг үндсээр нь өөрчилж буй хэрэг биш юм. Япон улсын Засгийн газар ямагт тайван байдлаар хандаж ирсэн. Өдгөө Япон улсын Засгийн газрын өмчлөлд шилжээд буй гурван арлаас бүрдэх газар нутаг нь 1932 он хүртэл Япон улсын Засгийн газрын эзэмшилд байжээ. Хожим нь, уг газар нутгийг хувь хүн худалдан авсан бөгөөд энэ удаад Японы Засгийн газраас түүнийг өөрийн

эзэмшилд буцаан авах шийвдэр гаргалаа. Үүнээс гадна, Засгийн газар нь Сэнкакү арлуудын бүрэлдэхүүнд орох Тайшоо арлыг өмчлөх эрхээ тууштай хадгалсаар иржээ.

- Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын зүгээс далайн орон зайд нэвтрэн орох оролдлогыг идэвхийлэн хийж, Сэнкакү арлын орчим өдөөн хатгалгын шинж чанар бүхий үйл ажиллагаа явуулах болов. Засгийн газрын өмчийн болон идэвхтнүүдийн хөлөг онгоцууд ар араасаа Япон улсын усан хилийг зөрчин нэвтэрч буй нь Япон улсад түгшүүр хуримтлуулсаар байгаа билээ. Ийм нөхцөлд Токио хотын захиргаанаас Сэнкакү арлуудыг худалдан авах төлөвлөгөөг гаргасан юм. Хэдийгээр Япон улсын Засгийн газар нь БНХАУ-ын зүгээс тавиад буй мэдэгдлийг хүлээн зөвшөөрөхгүй ч, өрнөөд буй хөдөлгөөнүүд нь Япон-Хятадын бодит харилцаанд ноцтой нөлөө үзүүлж болзошгүй хэмээн үзсэн билээ.
- Япон улсын хувьд, Япон-Хятадын харилцаа нь хамгийн чухал хоёр талын харилцаануудын нэг юм. Хоёр орны хоорондын найрсаг харилцаа нь Зүүн Ази дахь энх тайван, тогтвортой байдалд нэн чухал гэдэгийг хүлээн зөвшөөрдөгийн хувьд Япон улс нь хамтын ажиллагаагаа аль болох алсын хараатайгаар бэхжүүлсээр ирсэн билээ. Япон-Хятадын харилцаан дахь ирээдүйн өргөн боломжуудыг бодвол арлуудыг эзэмших эрхийг шилжүүлэх нь үрт хугацаанд тайван бөгөөд тогтвортой удирдлагаар хангах явдлыг баталгаажуулах хамгийн оновчтой бөгөөд сайн арга байсан юм.

3. Ямар ч шалтгаантай байсан хүчирхийллийн үйлдлүүдийг зөвтгөхгүй

- БНХАУ-ын хэд хэдэн бүс нутагт Японы эсрэг жагсаал цуглаан явагдаж, Японы дипломат төлөөлөгчийн газруудын зүг чулуу болон бусад аюултай эд зүйлс шидэх, япон иргэдийн эсрэг хэрцгий үйлдэл гаргах, Японы харьяа компаниудын эд хөрөнгийг галдан шатаах, сүйтгэх, тонон дээрэмдэх явдал гарсан нь нэн харамсалтай.
- Ямар ч шалтгаантай байсан хүчирхийллийн үйлдлийг зөвтгөх учиргүй бөгөөд үзэл бодлын зөрүүг тайван замаар илэрхийлэх нь зүйд нийцнэ. Энэ бол олон улсын хамтын нийгэмлэгийн нийтлэг ашиг сонирхол юм.